

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-Т ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ


/2022 оны эхний хагас жил/

“Монголросцветмет” ТӨҮГ-ын өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Засгийн газрын <https://zasag.mn> цахим хуудасны 11-11 мэдээллийн төв, Байгууллагын <http://mongolros.mn/> цахим хуудасны “Бидэнтэй холбогдох”, фэйсбүүк хаяг, Холбоо барих утас 1145-8072, 1145-8380 тоот утсаар болон бичгээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдол:

“Монголросцветмет” ТӨҮГ нь 2022 оны эхний хагас жилд 33 өргөдөл, 10 гомдол нийт 43 өргөдөл, гомдол хүлээн авсан байна.



Тайлант хугацаанд тендерт оролцогч нараас ШӨХТГ-т гаргасан гомдол 1, Сангийн яаманд гаргасан гомдол 9 байна. ШӨХТГ-т гаргасан гомдлыг тус газар хянаж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. Сангийн яам гомдлыг хянаж тендерийг бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн 1, тендерийн үнэлгээг дахин хийх 4, захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн 4 шийдвэр тус тус гаргасан.

“Монголросцветмет” ТӨҮГ нь Сангийн яамны гаргасан шийдвэрийн дагуу тус тус дахин тендерийг үнэлж, тендерийг дахин зарлаж тендер шалгаруулалтыг хуульд нийцүүлэн явуулж байна.

Мөн тайлант хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдлийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” тухай хуульд заасан хугацаанд багтаан хянан үзэж, шийдвэрлэн, хариу өгч ажилласан ба эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл шийдвэрлэлтийн байдал 90%тай байна.